Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Сургуулийн өмнөх боловсролын багшийн хөгжил хариуцсан арга зүйч, мэргэжилтэн, Дааваняам Нарантуяа

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. Багш, ажилтны мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж, мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх. | | | | | | | |
| 1 | Ментор багш нарыг бэлтгэж, Ментор хөтөлбөр хэрэгжүүлэх. | Ментор багш нарын тоо, хэрэгжүүлсэн хөтөлбөр | 3-(ментор багш) 0,03 (хувь) | Эхний хагас жил: Хөтөлбөрийн удирдамж боловсруулж бэлтгэл ажлыг эхлүүлсэн байна. | Сургуулийн өмнөх боловсролын салбарын хүрээнд өмнөх жилүүдэд 3 ментор багш бэлтгэгдсэн ба энэ хичээлийн жилд гурван ментор багшаар дамжуулан 5 ментор багш бэлтгэх зорилго тавин хөтөлбөрийн удирдамжийг холбогдох мэргэжилтнүүдийн хамт боловсруулсан. Хөтөлбөрийн удирдамжийн хүрээнд зөвлөх, ментор, Хан-Уул дүүргийн 209-р цэцэрлэгийн багш Б.Долгорсүрэн багштай хамтран ажиллаж байна. Хөтөлбөрийн удирдамж боловсруулснаар цаашид хэрхэн ажиллах ажлын чиглэл тодорхой болсон. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хавсралт: 1 файл | | |
| 2 | Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүний нөөцийн хөгжлийн чиглэлээр батлагдсан хууль, тогтоомж, шийдвэр, бодлогын баримт бичиг, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах. | Дүрэм, журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо, батлагдсан удирдамж, тайлан | 4000 (багш) 50 (хувь) | 1 (үйл ажиллагаа) 50 (хувь) | Боловсролын ерөнхий хууль батлагдсанаар сургуулийн өмнөх боловсролын холбогдох дүрэм, журам шинэчлэгдэн батлагдаж байна. Энэ хүрээнд Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн "Журам батлах тухай" А/25, 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн "Журам батлах тухай" А/37 дугаар тушаал тус тус батлагдан гарсан. Шинээр батлагдан гарсан журмуудыг танилцуулах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор аймаг, нийслэлийн Боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтсийн сургуулийн өмнөх боловсрол хариуцсан ахлах арга зүйч, хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйчдэд 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр цахим сургалт зохион байгууллаа. Сурглатад нийт 1427 цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч багш нар хамрагдав. Сургалтын үр дүнд шинээр батлагдсан хуулийн талаар нэгдсэн ойлголттой болгож, цаашид нэгж байгууллагууд хэрхэн хэрэгжүүлэх зөвлөмж, анхаарах асуудоын талаар дэлгэрэнгүй зөвлөгөө өгөн асууж тодруулах зүйлд | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хариулт өгөв. Сургалтыг Боловсролын яамны Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга, мэргэжилтнүүд, Боловсролын ерөнхий газрын сургуулийн өмнөх боловсрол хариуцсан холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран хийлээ. | | |
| 3 | Сургуулийн өмнөх боловсролын багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих үндсэн сургалт зохион байгуулах | Сургалтын батлагдсан удирдамж, хөтөлбөр, төлөвлөгөө. Оролцогчдын тоо, хувь | 1152 (багш) 80 (хувь) | 1400 (багш) 82 (хувь) | Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 2,7,12, 5,10,15,20 дахь жилдээ ажиллаж байгаа удирдах ажилтан, багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг танхим, цахим хосолсон хэлбэрээр 2025 оны 3 дугаар 26-аас 5 дугаар сарын 9-ний өдрийг дуусталх хугацаанд зохион байгууллаа. Танхимын сургалтад 1386 хамрагдахаас 1311 хамрагдаж 94.5%-ийн ирцтэйгээр сургалтад хамрагдсан. Үүнээс 994 багш, 149 эрхлэгч, 168 арга зүйч нар хамрагдсан. Удирдах ажилтны 2 дахь жилдээ ажиллаж байгаа 204, 7 дахь жилдээ ажиллаж байгаа 74, 12 дахь жилдээ ажиллаж байгаа 36 удирдах ажилтан, арга зүйчид хамрагдсан байна. 5 дахь жилдээ ажиллаж байгаа 508, 10 дахь жилдээ ажиллаж байгаа, 294, 15 дахь жилд 126, 20 дахь жилд 74 багш хамрагдсан байна. Цахим сургалтыг 4 дүгээр сарын 15- | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | аас 5 дугаар сарын 9-ний өдрийг дуустал хугацаанд зохион байгуулсан. Цахим сургалтыг GOOGLE CLASS ROOM анги дээр 3 анги үүсгэн зохион байгуулсан. Цахимд 1262 оролцогчийг анги тус бүрд бүртгэн хамруулснаас 1035 багш, удирдах ажилтан цахим сургалтадаа идэвхтэй оролцон тэнцэж батламж авах эрх үүссэн байна. Хамрагдалтын хувь 78% байв. Сургалтын дүнг танхимын сургалтын ирц, цахим сургалтын талбарт байршуулсан дасгал даалгавар, хэлэлцүүлэг, сорилын үнэлгээгээр гаргасан. Сургалтад хамрагдсан боловч тэнцээгүй 276, бүртгэлтэй боловч огт хамрагдаагүй 75 оролцогч байлаа. Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын үр дүнг зарим нэг багшаас постер, бичлэгээр хүлээн авч байгууллагын пэйж хуудсанд байршуулан олон нийтэд түгээсэн. Сургалтын үр дүнд оролцогчид эргэцүүлэлд суурилсан багшийн хөгжил яагаад чухал, багш, удирдах ажилтны цахим ур чадварыг дэмжсэн AI болон MOZABOOK цахим платформ, СӨБ-ын шинэчилсэн хөтөлбөрийн үзэл баримтлал, онол, арга зүйн талаар, мөн moes-н Google classroom дээр ажиллах | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | чадварыг нь дэмжсэн.Сургалын шинэлэг тал нь шинэчилсэн журмын хүрээнд сургалт зохион байгуулсан, сургуулийн өмнөх боловсролын сургалтын шинэчилсэн хөтөлбөрийн үзэл баримтлал, онцлог арга зүйг талаар нэгдсэнн ойлголт өгсөн зэрэг байв.<br>Хавсралт: 2 файл | | |
| 4 | Багшийн хөгжлийг дэмжих платформд суурилсан цахим сургалтын сан бүрдүүлэх | Платформд байршуулсан шаардлага хангасан цахим сургалтын тоо, чанар | - | 1 (сургалт) 50 (хувь) | Багшийн хөгжлийг дэмжих платформд суурилсан цахим сургалтын сан бүрдүүлэх зорилгоор Сургуулийн өмнөх боловсролын шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг үндэсний түвшний удирдах ажилтан, багш нарт хүргэхээр MOODLE платформыг ашиглахаар бэлдэн ажиллаж байна. Мөн Medlee.mn дээр багшийн хөгжлийг дэмжих, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх цэс үүсгэн олон нийтэд хүргэх боломжийг судлан ажиллаж байна. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 50% |
| 5 | Багш солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх, хамтран ажиллах | Хөтөлбөрийн батлагдсан удирдамж, төлөвлөгөө, оролцогчдын тоо, чанар | 3 (оролцогч) 100 (хувь) | - | Төлөвлөсөн ажлыг сүүлийн хагас жилд хийхээр төлөвлөсөн тул эхний хагас жилд хийхээр төлөвлөсөн. Эхний хагас жилд газрын мэргэжилтнүүдтэй хамтран багш солилцооны хөтөлбөрийг хэрхэн зохион байгуулах ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийн эхний | 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хувилбарыг ярилцаж, хувилбар байдлаар боловсруулаад байна. | | |
| 6 | Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багшид мэргэжлийн “Зөвлөх” зэргийн материалд дүгнэлт гаргах, олгох ажлыг зохион байгуулахад хамтран ажиллах | Дүгнэлт гаргасан тоо, зөвлөх мэргэшлийн зэрэг авсан багшийн тоо | 100 | 50 | 2024 онд Сургуулийн өмнөх боловсролын түвшинд нийт 56 зэргийн материал ирүүлсэнд холбогдох мэргэжилтнүүдийн хамт дүгнэлт гарган 42 удирдах ажилтан, багш тэнцсэн. 2025 онд Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багшид мэргэжлийн “Зөвлөх” зэрэг олгох шалгуур өөрчлөгдсөн тул шинэчилсэн журамд санал өгч ажилласан. Боловсролын сайдын 2024 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн тушаалаар батлагдсан "Хүүхдийн цэцэрлэгийн багш, арга зүйч, эрхлэгчид мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журам"-ын 4.3.дахь хэсгийн Багш, удирдах ажилтан дараах материалыг боловсролын мэдээллийн нэгдсэн системд цахим хэлбэрээр бүрдүүлнэ. гэсний дагуу системд цахим хэлбэрээр бүрдүүлэхэд шаардагдах шалгуурыг холбогдох мэргэжилтнүүдийн хамт боловсруулж, цахим нэгдсэн статистикийн газарт хүлээлгэн өгсөн. | 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 7 | Сургалтын байгууллагын | Зөвлөн тусалсан МХБ-ийн тоо, үр | 30 (МХБ-ийн тоо) 3 (сайн | 36 (МХБ-ийн тоо) 5 (сайн | Сургуулийн өмнөх боловсролын шинэчилсэн | 1-р сар, 2-р сар, 3-р | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | “Мэргэжлийн хөгжлийн бүлэг”-ийн үйл ажиллагаанд зөвлөн тусалж, үндэсний хэмжээнд тайлант өдөрлөг зохион байгуулж, үр дүнтэй МХБ-ийн сан бүрдүүлэх. | дүнтэй МХБ-ийн тоо | туршлагын тоо) | туршлагын тоо) | хөтөлбөрийг 18 цэцэрлэг дээр туршин хэрэгжүүлж байна. Туршилтын цэцэрлэгт зөвлөн туслах ажлаар явангаа Дархан-Уул аймгийн 27, Шарын гол сумын 4-р цэцэрлэг, Хэнтий аймгийн Хэрлэн сумын 4-р цэцэрлэг, Баянзүрх дүүргийн 200-р цээцрлэг, Сонгинохайрхан дүүргийн 110-р цэцэрлэг, Чингэлтэй дүүргийн 275-р цэцэрлэгүүдийн 5 мэргэжлийн хөгжлийн бүлэгт 2024 оны 11 дүгэрр сараас 2025 оны 3 дугаар сарыг дуусталх хугацаанд төлөвлөсний дагуу зөвлөн тусалж ажилласан. Эдгээр мэргэжлийн хөгжлийн бүлгүүдээс үр дүнтэй ажиллаж байгаа нь Дархан-Уул аймгийн бүлэг байв. Зөвлөн туслахын ажлын үр дүнд: - Багш нарын хамтын ажиллагааг хэрхэн илүү сайжруулах, мэргэжлийн хөгжлийн бүлэг юун дээр илүү анхаарч ажиллах - Бүлгийн гишүүдийг хэрхэн чадавхжуулах - Сайн туршлагын чиглэлийг хамтдаа томьёолж, туршлагын санг аймаг, дүүрэгтээ үүсгэх - Цаашид юун дээр анхаарч ажиллах талаар ойлголтоо нэмэгдүүлсэн. | сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |
| 8 | СӨБ-ын багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжих | Сургалт, үйл ажиллагааны батлагдсан | Сургалт-1, бусад үйл ажиллагаа- | - | Цахим аялал интерактив хичээлийг таниулах, хэрэглээ болгох онлайн сургалтыг 21 | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сургалтаас бусад олон талт (эрдэм шинжилгээний болон онол практикийн бага хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэг, түншлэл, хамтын үйл ажиллагаа) ажлыг зохион байгуулах. | хөтөлбөр, удирдамж, тайлан. Оролцогчдын тоо | 2, оролцогч-2000 | | аймаг, 9 дүүргийн 8000 гаруй багшид 2025 оны 1 дүгээр сарын 31-ны өдөр 12,00-16,30 хүртэл зохион байгууллаа. Онлайн сургалтын зорилго нь “Цахим аялал” интерактив контентын арга зүйг өдөр тутмын сургалт, үйл ажиллагаанд хэрэглээ болгоход багш нарт дэмжлэг үзүүлэх байлаа. Сургалтыг мэдээлэл, зөвлөмж, дадлага хэлбэрээр зохион байгуулав. Сургалтыг НҮБ-ын Хүүхдийн сан, Номадик контент ХХК хамтран зохион байгуулсан ба сургалтын нээлтэд БЕГ-ын дарга, НҮБ-ын Хүүхдийн сангийн суурин төлөөлөгч нар оролцлоо.Сургалтын үр дүнд цахим интерактив хичээлүүдийг өдөр тутмын сургалт, үйл ажиллагаандаа хэрхэн хэрэглэх арга зүйд суралцсан. Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Сургуулийн Өмнөх Боловсролын Сургууль (МУБИС-СӨБС) нь "Бага насны хүүхдийн хөгжил, боловсрол, судалгаа - ECDER 2025" олон улсын эрдэм шинжилгээний хурал 2025 оны 2 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулагдсан. Тус хуралд оролцох урилга ирсэн учир хуралд оролцон, олон улсын эрдэмтдийн бага насны хүүхдийн хөгжил боловсролын | сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | талаарх болон СӨб"ын багшийн хөгжлийн талаарх сонирхолтой судалгаануудыг сонсон, сонирхсон асуултуудаа асууж, ажилдаа хэрэг болох шинэ санаануудыг олж авлаа. “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй”сэдэвт онол, практикийн ix бага хурлын илтгэлийн нэгдүгээр шатанд СӨБ-ын байгууллагаас ирсэн 15 илтгэлийг уншиж, дүгнэлт гарган хүлээлгэн өгөв. СӨБ-ын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, зураглал, 4 удаагийн сургалтын төсөь, удирдамж хийж Боловсролын яамны СӨБ-ын хэлтэст хүлээлгэн өгсөн. Тус ажлын хүрээнд мэдээлэл солилцох, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт, явцтай танилцах уулзалтыг 2025 оны 4 дүгээр сарын 7, 15, 25, 5 дугаар сарын 9,23-ны өдрүүдэд зохион байгуулаад байна. Уулзалтаар ажлын төлөвлөгөөний төлөвлөсөн ажлуудаа хэлэлцэх, цаашид юун дээр анхаарч, ажлаа эрчимжүүлж ажиллах зэргээр хэлэлцэв. Тус уулзалтад БЕГ, БСҮХ, БҮТ-ийн мэргэжилтнүүд оролцлоо. | | |
| 9 | Сургуулийн өмнөх | Хамтран | - | 12000 (СӨБ-ын | Сургуулийн өмнөх болон бага | 1-р сар, 2-р | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсролын сургалтын шинэчлэн боловсруулсан хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах | боловсруулсан хөтөлбөр, сургалтад хамрагдсан багшийн тоо, хувь | | багш, удирдах ажилтан) | боловсролын сургалтын хөтөлбөр, сурагчийн гарын авлага, дасгал ажлын дэвтрийг ii улиралд турших багш нарыг бэлтгэх сургалт 2025 оны 1 дүгээр сарын 14,15-ны өдрүүдэд Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгээс хөтөлбөр боловсруулагчидтай хамтран зохион байгуулав. Сургалтын зорилго: Сургуулийн өмнөх боловсролын шинэчилсэн сургалтын хөтөлбөр, багшийн гарын авлага, дасгал ажлын дэвтрийг II улиралд турших багш, удирдах ажилтны ойлголтыг нэгтгэх, таниулах, хэрэгжүүлэх арга зүйн дэмжлэг, туршилтын зохион байгуулалтыг танилцуулах байлаа. Сургалтад СӨБ-ын сургалтын хөтөлбөр турших цэцэрлэгийн арга зүйч, багш нийт 97 хүн хамрагдлаа. Сургалтад 2024 оны XI, XII сарын 3,4-р долоо хоногийн СҮД-д шинжилгээ хийх (4 багаар), багш нарын хийсэн үнэлгээнд шинжилгээ хийх, төлөвлөлтийн дагуу СҮА-г заах, сайжруулах (баг), Багшийн эргэцүүлэмжид шинжилгээ хийх 11-12 сарын гэсэн агуулгуудаар хичээл бэлдэн 2 өдөр ажиллав. СӨБ-ын хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд хэл ярианы болон | сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бэлтгэл бүлгийн багшт ажиллан, багшийн гарын авлага, дасгал ажлын дэвтрийг холбогдох хүмүүстэй хамтран боловсруулах ажил үргэлжилж байна. Туршилтын цэцэрлэг, сургуулийн удирдлага болон орон нутгийн боловсролын газрын мэргэжилтэн нартай менежментийн зураглал, төлөвлөгөө гаргах, туршилтын дараах судалгааны мэдээлэл цуглуулах ажлаар Хэнтий аймгийн 9-р цэцэрлэг дээр 3 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд ажиллав. Ажлын үр дүнд тус аймгийн Боловсролын газрын мэргэжилтнүүд, аймгийн төвийн зарим сургуулийн захирал, менежерүүд, бага ангийн багш нар, СӨБ-ын байгууллагын эрхлэгч, арга зүйч, багш нарын нийт 30 хүнтэй орон нутагт шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх менежментийг зураглал гаргагахад хамтран ажиллаж чиглүүлэв. Шинэчилсэн хөтөлбөрийн үзэл баримтлал, онол арга зүйг таниулах цахим сургалтыг 2025 оны 5 дугаар сарын 28-ны өдөр цахимаар зохион байгуулсан. Сургалтад орон нутаг, нийслэлийн 9000 гаруй багш, удирдах ажилтнууд нэг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | цэгээс хамрагдсан. | | |
| 10 | Цэцэрлэгийн менежмент-2025 арга хэмжээг үндэсний хэмжээнд зохион байгуулахад хамтран ажиллана. | Арга хэмжээнд хамрагдсан цэцэрлэг, оролцогчдын тоо | 117 (цэцэрлэг) 35 (сайн туршлага) | - | Цэцэрлэгийн менежмент-2025 арга хэмжээг үндэсний хэмжээнд зохион байгуулах ажлын удирдамж, төсвийг боловсруулаад байгаа, энэ арга хэмжээг сүүлийн хагас жилд зохион байгуулна. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 3.1. Нэгжийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг мөрдөн ажиллах | | | | | | | |
| 11 | Нэгжийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг мөрдөн ажиллах | Хэрэгжилт /хувь/ | 100 | 100 | Нэгжийн долоо хоног бүрийн хуралд оролцон өөрийн албан тушаалын хүрээнд холбогдох хууль дүрмийг судлан цаашид хүүхдийн цэцэрлэг дээр хэрэгжүүлэх 2-3 удаагийн сургалтуудыг зохион байгуулсан. Ажил үүрэгтэй холбоотой нэгжийн даргаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүр хийж гүйцэтгэж байна. Мөн холбогдох ажлын хүрээнд нийт 7 албан бичиг төлөвлөж явуулсан байна. Иргэдээс 2 гомдол ирснийг зохих журмыг дагуу шийдвэрлэсэн. Байгууллагын дотоод журам болон бусад холбогдох хууль дүрэм, журмыг дагаж мөрдөн ажиллаж байна. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 12 | Ерөнхий газрын | Биелэлт /хувь/ | 100 | 100 | Байгууллагын болон нэгжийн, | 1-р сар, 2-р | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | даргын шуурхай хурал, даргын зөвлөлийн хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах | | | | өөрийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулах ажлын хүрээнд 2025 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр Боловсролын яаман дээр болсон СӨБ-ын хэлтсийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийн хэлэлцүүлэгт оролцон, нэгжийн болон өөрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах ажлуудыг тусган төлөвлөгөөг боловсруулан батлуулсан. Ерөнхий газрын даргын шуурхай хурал, даргын зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүр хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |
| 13 | Архив, албан хэрэг хөтлөлтийн журмыг хэрэгжүүлж, эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын нэгж болгон хадгалуулах | Биелэлт /хувь/ | 100 | 100 | Архив, албан хэрэг хөтлөлтийн журмыг хэрэгжүүлж, эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын нэгж болгон хадгалуулахаар бэлэн болгож өгсөн. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 14 | Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс | Биелэлт /хувь/ | 100 | 100 | Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан чиг үүргийг | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх | | | | хэрэгжүүлэхтэй холбоотой тухайн хуулиудыг судлах, бусдад урьдчилан сэргийлэх ажлыг сургалт зохион байгуулах явцад зөвлөх зэргээр хэрэгжүүлж байна. | сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах дотоодын сургалтуудад хамрагдах | Сургалт тус бүрийн зорилго зорилтын хүрээн дэх мэдлэг чадварыг эзэмшиж, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлнэ. | Өмнөх жилүүдэд 4 сургалт, бусад үйл ажиллагаа 2 | Сургалт 1, бусад үйл ажиллагаа 1 | Байгууллагаас зохион байгуулсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийг ойлгон, хэрэгжүүлэх сургалтад хамрагдаж өөрт хэрэгтэй мэдээллийг авсан. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 2 | Ажил үүргийн холбогдолтой шинээр батлагдсан хууль, тогтоомж, тогтоол, | Ажил албан тушаалын хүрээнд шинээр батлагдан гарсан хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийг судалж, хэрэгжүүлэхэд | 100 | 100 | Ажил үүрэгтэй холбоотой шинээр гарсан "Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийх | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шийдвэрийг судлах | хамтран ажиллах, өөрийн ажилдаа тусган хэрэгжүүлнэ. | | | журам", "Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх журам"-ын хэрэгжилтийг хангаж ажиллахын хүрээд 1 удаагийн цахим суургалтыг үндэсний хэмжээний хүүхдийн цээцрлэгийн багш, удирдах ажилтан нийт 10000 гаруй хүнд зохион байгуулсан. Цахим сургалтын үр дүнд байгууллага өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийхдээ ямар шалгуураар яаж хийх, үнэлгээ хийснээр ямар ач холбогдолтой, үр дүнг нь хэрхэн яаж ашиглах талаар ойлголттой болсон. Мөн багш, ахжилтнууд мэргэжлээ хэрхэн дээшлүүлэх, мэргэжлийн багш нарын бүлгээр хэрхэн ажиллах талаар ойлголтоо нэгтгэсэн гэж үзэж байна. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөийн шинэчлэлийн хүрээнд Боловсролын тунхаг бичиг, СӨБ болон ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалтай уншиж танилцан мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын агуулгад тусган нийт 1311 багш, удирдах ажилтнуудад түгээн дэлгэрүүлсэн. | 10-р сар, 11-р сар, 12-р сар | |
| 3 | Монгол бичгийн ур чадвараа бие | Монгол бичгийн ур чадвараа нэмэгдүүлэх | 1 сургалт | 2 сургалт | Монгол бичгийн ур чадвараа бие даан тасралтгүй | 1-р сар, 2-р сар, 3-р сар, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | даан тасралтгүй хөгжүүлэхийн тулд сургалтад хамрагдах | чиглэлээр бие даан суралцана. | | | дээшлүүлэн унших, бичих чадвараа нэмэгдүүлж байна. | 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Сургуулийн өмнөх боловсролын багшийн хөгжил хариуцсан арга зүйч, мэргэжилтэн, Давааням Нарантуяа
/................................................/ Огноо: ........................